



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 02/52

Баян-Өндөр сум

Тогтоолуудын зарим заалтад
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Орхон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 02/01 дүгээр тогтоолын 2 дугаар заалтын “.. жил бүрийн IV улиралд багтаан ...”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн “Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” 18/02 дугаар тогтоолын 2 дугаар заалтын “... 2025 оны IV улиралд багтаан ...”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/15 дугаар тогтоолын 2.3 дугаар заалтын “... жил бүрийн IV улиралд багтаан ...” гэснийг “дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан ...” гэж тус тус өөрчилсүгэй.

ДАРГА



Д.МӨНХБАТ

6125010140